



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 07 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар ТУЗ 2023-03/05

Улаанбаатар
хот

**Компанийн эргүүлэн худалдаж авах
нэгж хувьцааны үнийг тогтоож батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, 55.6, 55.7, 76 дугаар зүйлийн 76.1.6, Хараат бус үнэлгээний байгууллагын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хувьцааны үнэлгээний тайлан, Хөндлөнгийн аудитын байгууллагын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 23/37 дугаартай хараат бус аудиторын тайлан, “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.6 дах заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэр өөрчлөхтэй холбогдуулан эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааг үнийг 68,880 /Жаран найман мянга найман зуун наян/ төгрөгөөр тогтоосугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан компанийн эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааг үнийг тогтоосонтой холбоотойгоор Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан компанийн эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааг үнийг тогтоосонтой холбоотойгоор “Жуулчин Дюти Фрий ХК-ийн хувьцаа эргүүлэн худалдаж авах журам”-ыг хавсралт №1-р баталсугай.
4. Хувьцаа эргүүлэн худалдан авах ажиллагааг санхүүгийн бүхий л боломжит нөөц бололцоогоо дайчлан, эрх бүхий байгууллагатай хамтран хуульд нийцүүлэн зохион байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Ц.Отгонбаяр/, ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү шийдвэрийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хуульд заасны дагуу хэвлэн мэдээлэхийг Маркетингийн менежер /Б.Намуун/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН